


Монгол улсын зүүн ази дахь бодлого


С.ОНОН

Б.МӨНХСАРНАЙ

Ц.НОМИН-ЭРДЭНЭ



Зүүн хойд Азийн бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдлын асуудлыг яриа хэлэлцээ, энх тайван замаар шийдэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачлагыг олон улсад таниулахаар ажилсан . Энэ санаачлагыг бодит ажил хэрэг болгох зорилтын хүрээнд “Эрчим хүчний хэлхээ холбоо” Зүүн хойд Азийн орнуудын шинжээчдийн түвшний анхдугаар уулзалт, “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын эрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурал, Зүүн Хойд Азийн залуучуудын анхдугаар уулзалт, Зүүн Хойд Азийн хотын дарга нарын хоёрдугаар уулзалт зэргийг эх орондоо зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнд Зүүн Хойд Азийн бүх орон оролцсон нь манай санаачлага тус бүс нутагт яриа хэлэлцээ хийх бодит талбар болсон гэж үзнэ. Энэ онд энэ санаачлагаа улам урагшлуулах чиглэлээр уламжлалт уулзалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна



Монгол Улс Зүүн Азийн дээд түвшний уулзалт (ЗАДТУ)-д нэгдэх сонирхолтой, түүнийгээ 2 талын шугамаар асуудал тавьж ирсэн байдаг. Энэ зорилтоо бодит ажил хэрэг болгох чиглэлээр анхаарч ажилсан. Энэ хүрээнд тус байгууллагын албан бус нарийн бичгийн дарга нарын газар болох АСЕАН болон Зүүн Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн (ERIA)-тэй ойр ажиллаж ирэв. Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн, Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг нар ERIA-ийн удирдлагатай уулзалт хийж хамтран хийх судалгааны чиглэлүүдийг тодорхойлж энэ сараас эхний ээлжийн судалгааг эхлүүлэх чиглэлээр ажиллаж байна.